



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/385

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "б" дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн Нэмэлт санхүүжилтийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, орон нутагт төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу зөв зохистой ашиглах, орон нутгийн бодлого үйл ажиллагаатай уялдуулах, зөвлөмжөөр хангах зорилгоор төслийг удирдах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	-Хэнтий аймаг дахь төслийн ажилтан
Гишүүд	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн
	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга
	-Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг дунд үйлдвэр дэмжих дэд сан, Зээлийн батлан даалтын сан, Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн
	-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

2//.

2. Төслийн үйл ажиллагааг орон нутгийн бодлоготой уялдуулж, ажлын хэсгийн гишүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА